

Нарны цацрагийн ажиглалтын голлох элемент, үзэгдэл

Элемент	Хэмжигдэхүүний нэр	Хэмжлийн нэгж	Боловсруулалт	Тодорхойлолт
		Нэр/ тэмдэглээ		
Шулуун цацрагийн хэмжээ /S, S'/	тухайн хугацааны	квадрат метр дэх Ватт /Вт/м ² /	хугацаа, сар	Нар болон түүний эргэн тойрны 5 градус радиус дотроос газрын гадаргад шууд ирж байгаа цацрагийн зэрэгцээ урсгалыг нарны шулуун цацраг гэнэ. Энэ цацрагийг S үсгээр тэмдэглэнэ. Нарны шулуун цацрагийн урсгалд эгц босоо /перпендукуляр/ байрлуулсан актонометр, пиргелиометрээр нарны шулуун цацрагийг хэмжинэ. Хэвтээ гадаргад ямар нэг өнцгөөр тусаж байгаа шулуун цацрагийн S' гэж тэмдэглэх бөгөөд дараах томъёогоор олно. S' = S x Sinh ₀ h ₀ – нарны өндөр
Сарнисан цацрагийн хэмжээ /D/	тухайн хугацааны	квадрат метр дэх Ватт /Вт/м ² /	хугацаа, сар	Нарны цацраг агаар мандлын хийн молекул, усан дусал, тоос, шороо, үүл зэрэгт саатаж, зүг бүр тийш сарнисны дараа газрын гадарга дээр ирэхийг сарнисан цацраг гэнэ. Энэ цацрагийг D үсгээр тэмдэглэнэ. Шулуун цацрагийг хааж /сүүдэрлэсэн/ пиранометрээр сарнисан цацрагийг хэмждэг.
Нийлбэр цацраг хэмжээ /Q/	тухайн хугацааны	квадрат метр дэх Ватт /Вт/м ² /	хугацаа, сар	Хэвтээ гадарга дээр тусаж байгаа шулуун цацраг (S) ба сарнисан цацрагийн нийлбэрийг нийлбэр цацраг гэж нэрлэнэ. Энэ цацрагийг Q үсгээр тэмдэглэнэ. Q = D + S'
Ойсон цацрагийн хэмжээ / Rk/	тухайн хугацааны	квадрат метр дэх Ватт /Вт/м ² /	хугацаа, сар	Идэвхтэй гадаргад ирж байгаа нийлбэр цацраг хөрс, ургамал, усан бүрхэвчид шингэх төдийгүй зарим хэсэг нь тэдгээрээс ойх ба үүнийг ойсон цацраг гэнэ. Энэ цацрагийг Rk гэж тэмдэглэнэ.

Богино долгионт цацрагийн баланс /Вк/	тухайн хугацааны	квадрат метр дэх Ватт $/Вт/м^2/$	хугацаа, сар	Нийлбэр цацрагийн идэвхтэй гадаргад шингэсэн хэсгийг нарны богино долгионт цацрагийн баланс гэнэ. Үүний Вк гэж тэмдэглэн дараах томъёогоор тооцно. $Вк = Rk - Q$
Урт долгионт цацрагийн баланс /Вд/	тухайн хугацааны	квадрат метр дэх Ватт $/Вт/м^2/$	хугацаа, сар	Агаар мандлын урт долгионт (агаар мандлаас газрын гадарга уруу чиглэсэн) идэвхтэй гадаргын урт долгионт (газрын гадаргаас агаар мандал уруу чиглэсэн) цацрагуудын ялгаварыг урт долгионт цацрагийн баланс $Вд = Eа - (Eз + Eд)$ гэж ойлгоно.
Гадаргын ойлт /Ак/	тухайн хугацааны	квадрат метр дэх Ватт $/Вт/м^2/$	хугацаа, сар	Нийлбэр ба ойсон цацрагийн хэмжээгээр идэвхтэй гадаргын ойлгох чадвар буюу ойц /альбедо/-ыг дараах томъёогоор тооцоолж гаргадаг. $Ак=Rk/Q$ Ак-идэвхтэй гадаргын ойц